



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/520 .

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6а заалт Газрын тухай хуулийн 57.3, 57.4 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Жаргалант сумын нутаг дэвсгэрт Газрын тухай хууль, тогтоомж зөрчин зохих зөвшөөрөлгүйгээр барилга байгууламж барьсан, эсхүл бусад хэлбэрээр дур мэдэн газар эзэмшиж, ашигласан иргэн, аж ахуй нэгж, байгууллагын зөрчлийг арилгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Гантөмөр-Жаргалант сумын Засаг дарга  
Б.Батзаяа-Ховд аймаг дахь Цагдаагийн газрын дарга

Б.Эрдэнэбат -Ховд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй хаалттай хорих ангийн дарга

Нарийн бичгийн дарга: Б.Баярсүх- Аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын дарга

2.Зөрчил арилгах ажлыг 2019 оны 08 дугаар сарын 26-ны дотор гүйцэтгэж, тайланг 2019 оны 08 дугаар сарын 30-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /С.Гантөмөр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

